УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2022 оны 06 сарын 29 өдөр Дугаар А/112 Улаанбаатар хот

Авто замын байгууламжийн арчлалтын
ажилд хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Нийслэл Улаанбаатар хотын Эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4, 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.12, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны "Нийслэлийн 2022 оны төсөв батлах тухай" 11/34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/668 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хотын авто замын эгнээ тусгаарлах хайсны бүрэн бүтэн байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор батлагдсан Авто замын эгнээ тусгаарлах хайс хашлага арчлах, нөхөн сэргээх ажлын задаргааг 1 дүгээр хавсралтаар, Гүүрийн байгууламж, нүхэн гарцын байгууламжийн ашиглалт, үйлчилгээний зардалын задаргааг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дээрх 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан ажлыг батлагдсан зардлын хүрээнд байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-аар гэрээгээр гүйцэтгүүлж ажиллахыг Хотын инженерийн байгууламжийн хэлтэс (Ц.Нямцэвээн)-д даалгасугай.

3. Авто замын эгнээ тусгаарлах хайс хашлага арчлах, нөхөн сэргээх ажилд шаардагдах 500,000,000 (Таван зуун сая) төгрөг, Гүүрийн байгууламж, нүхэн гарцын байгууламжийн ашиглалт, үйлчилгээний зардал-ын 200,000,000 (Хоёр зуун сая) төгрөгийг Хот нийтийн аж ахуй тохижилт үйлчилгээний 2022 оны төсвийн зардлын задаргааны Хөтөлбөр 6. Авто зам, замын байгууламжийн чиглэлээр хэрэгжүүлэх ажлын 6.1, 6.2-т тусгагдсан урсгал зардлаас тус тус гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Ч.Алтанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (С.Жамъяндорж)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ГАНБОЛД

C:\Users\User\Desktop\ҮЖ 12\doc 2022\тушаал.docx

1110300689

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2022 оны ...06... сарын ..29..-ны өдрийн
А/112 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АВТО ЗАМЫН ЭГНЭЭ ТУСГААРЛАХ ХАЙС ХАШЛАГА АРЧЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ЗАРДАЛ

Бетон хаалт, хайс байрлуулах /тоноглолтой/

№	Байршил	Тоо хэмжээ у/м	Нэгж өртөг төгрөг	Нийт өртөг төгрөг
1	Баянгол дүүрэг, Нарны зам Барс захын ард	650	400 000	260,000,000
2	Зөөврийн хайс	500	195 000	97,500,000
	Нийт			357,500,000

Өнгө үзэмжгүй, будах шаардлагатай хашлаганы байршлууд

№	Байршил	Тоо хэмжээ у/м	Нэгж өртөг төгрөг	Нийт өртөг төгрөг
1	БЗД, СБД, ЧД, БГД, СХД Энхтайваны өргөн чөлөө, уулзварын хашлага будах	1443.6	18 800	27,140,000
2	СБД, ХУД, Чингисийн өргөн чөлөө, уулзварын хашлага будах	700	18 800	13,160,000
	Нийт	2143,617		40,300,000

Цацруулагч байршуулах

№	Байршил	Тоо хэмжээ у/м	Нэгж өртөг төгрөг	Нийт өртөг төгрөг
1	БЗД, ХУД, Богд уулын арын зам	1000	30 000	30,000,000
2	ХУД, СХД, Сонсголонгийн зам			
3	ХУД, Наадамчдын зам			
	Нийт	1000		30,000,000

Нөхөн байршуулах

№	Байршил	Тоо хэмжээ у/м	Нэгж өртөг төгрөг	Нийт өртөг төгрөг
1	Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж, Эрүүл мэндийн яамны уулзвараас урагш Континентал зочид буудлын уулзвар хүртэл	72	200,000	14,400,000
2	Сүхбаатар дүүрэг, Чингэлтэйн өргөн чөлөө 32 уулзвараас 17 уулзвар хүртэл	94	200,000	18,800,000
	Нийт	166		33,200,000

Хайсны сэлбэг, тоноглол

№	Байршил	Нийт өртөг /төгрөг/
1	БЗД, СБД, ХУД, ЧД, БГД, Энхтайваны өргөн чөлөө, Чингисийн өргөн чөлөө, Их тойруу, Намъянжугийн гудамж, Үндсэн хуулийн гудамжны эгнээ тусгаарлах шар хайсны тоноглол	39,000,000
	Нийт	39,000,000
	Нийт дүн	**500,000,000**

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2022 оны ..06..., сарын 09...-ны өдрийн
А/112..... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГҮҮРИЙН БАЙГУУЛАМЖ, НҮХЭН ГАРЦЫН БАЙГУУЛАМЖИЙН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

№	Байршил	Нийт өртөг /төгрөг/
1	Баянзүрх дүүрэг, Сансрын явган хүний нүхэн гарцын засварын ажил	58,351,697
2	Чингэлтэй дүүрэг, Бөмбөгөрийн явган хүний гүүрэн гарцын засварын ажил	16,174,000
3	Сүхбаатар дүүрэг, 100 айлын явган хүний гүүрэн гарцын засварын ажил	18,072,000
4	Хан-Уул дүүрэг, 19-ийн явган хүний гүүрэн гарцын засварын ажил	20,768,000
5	Хан-Уул дүүрэг, 120-н явган хүний гүүрэн гарцын засварын ажил	47,191,000
	Нийт дүн	**200,000,000**